# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

***Тайланг хянасан:***

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ..................................... А.ЭНХМАНЛАЙ

***Тайланг хүргүүлсэн:*** ***Төсвийн Шууд захирагч***

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА ..................................... Б.САРУУЛТӨГС

2024.12.03

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

*/2024 оны жилийн эцсийн байдлаар/*

## НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.2.<br>Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станцыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил зураглалын үйл ажиллагаанд ашиглана.** | | | | | | | |
| **1.2.1** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын үйл ажиллагаа** | **Үйл ажиллагаа** | **1. Байнгын ажиллагаатай станц-43<br>2. Бодит агшны хяналтын хэмжилт - 4** | **2013-2017 онд Улсын төсвөөр 38, УБ хотын төсвөөр 5 станц суурилуулсан.<br>2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн.** | **43 Байнгын ажиллагаатай станцыг нэгдсэн сүлжээнд холбогдож, солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоонд алдаагүй зөв хэмжилт хийх боломж бүрдсэн байна.** | | |
| 1.2.1.1 | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Байнгын ажиллагаатай станцын тоо | 2013-2017 онд Улсын төсвөөр 38, нийслэлийн төсвөөр УБ хотод 5 станц суурилуулсан.<br>2019 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 43 станцын нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэн. | GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна. | Тайлант онд Хүдэр суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар SEA3 нэртэй навигацийн хиймэл дагуулын байршил тодорхойлох байнгын ажиллагаатай суурин станцыг ашиглалтад оруулсан бөгөөд ингэснээр Сэлэнгэ аймаг нь Сүхбаатар суманд SEA1, Мандал суманд SEA2, Хүдэр суманд SEA3 нэртэй байнгын ажиллаагаатай GNNS-ийн 3 станцтай болсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тус GNSS-ийн байнгын ажиллагаатай 3 станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна. | |
| 1.2.1.2 | Аймгийн төвийн GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцыг бодит агшны хэмжилтээр хяналт тавих | Үйл ажиллагаа | Бодит агшны хяналтын хэмжилт - 4 | 2020 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын удирдлагын программ хангамжийг шинэчилж, хэрэглээнд нэвтрүүлсэн. | Аймгийн төвд суурилуулсан станцын бодит агшны нарийвчлалыг улиралд 1 удаагийн шалгалтын хэмжилт, сум суурин газрын станцуудад хагас жилд 1 удаагийн шалгалтын хэмжилт хийж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Аймгийн төвд ажиллаж буй суурин станцыг ашиглан Trimble r4 маркийн 2 долгионы GPS-ээр нийт 6 цэгт бодит агшны RTK хэмжилтийг 4 удаа хийж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т улирал бүр *\\192.168.20.24\Geodesy\GNSS хяналт хэмжилт 2024\IV улирал\Сэлэнгэ хяналтын хэмжилт 2024*" холбоост байршуулан хүргүүлсэн. | 100 |
| 1.2.1.4 | Ажиллагаагүй болсон GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 станцыг хэвийн ажиллагаанд оруулах | Урсгал төсөв | Байнгын ажиллагаатай станцын шинэчлэлт | Байнгын ажиллагаатай суурин станцын эх хавтан шатсан. | **Жилийн эцэст:** Хэвийн ажиллагаанд орсон станцыг шалган хүлээн авч, хэмжил зураглалын ажилд ашиглуулсан байна. | Мандал сумын GNNS-ийн байнгын ажиллагаатай SEA2 станц гэмтэлтэй байсныг засварлахад шаардлагатай хөрөнгийг байгууллагаас шийдвэрлэж, Гео-Инструмент ХХК-тай гэрээ байгуулан, шалтгаан нөхцөлийг олж тогтоон эх хавтанг сольж, SEA2 станцыг хэвийн ажиллагаанд оруулж ажилласан. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.7.**<br>**Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| **1.7.1** | **Газар ашиглалт болон газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх** | **Улсын төсөв** | **Мониторингийн 350 цэг** | **2021 онд мониторингийн сүлжээгээр байгуулсан 500 цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил хийгдсэн.** | **Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээний 1100 цэгээс мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, бусад байгууллагууд ашиглах нөхцөл боломжоор хангагдсан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7.1.2 | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх шаардлагатай газрын байршил, хугацаа, хуваарийн талаарх судалгааг аймгийн хэмжээнд гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | 1 судалгаа | - | **Эхний хагас жилд:** Сум болон холбогдох байгууллагаас газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийгдсэн газрын байршил, хугацааны талаарх судалгааг авч нэгтгэнэ. Тус судалгаанд дүн шинжилгээ хийж газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх шаардлагатай газрын байршил, хугацаа, хуваарийн талаарх судалгааг аймгийн хэмжээнд гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлнэ. | Тайлант онд аймгийн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэсэн нэгж талбарын судалгааг сум тус бүрээс авч, загвар хүснэгтийн дагуу нэгтгэн 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/203 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлж ажилласан.<br>Мөн Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5 дахь хэсэг болон Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх журмын 2.3-т тус тус заасны дагуу аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх шаардлагатай бэлчээр, тариалан, хот, тосгон бусад суурины эдэлбэр газрын байршил, талбайн хэмжээний судалгааг гарган, шаардлагатай төсвийг 2025 оны орон нутгийн төсөвт тусгуулахаар саналыг 2024 оны 01/398 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад хүргүүлэн ажилласан. | 100 |
| **1.7.2** | **Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих** | **Орон нутгийн төсөв** | **Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо** | **Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө батлагдсан. Газрын мониторингийн системийг хэрэглээнд нэвтрүүлснээр газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хянах боломж бүрдсэн.** | **Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалан болон атаршсан газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломж бүрдсэн байна.** | | |
| 1.7.2.1 | Аймгийн хэмжээнд хохирол учирсан, доройтолд өртсөн газруудын байршлыг гаргаж, нөхөн сэргээх байршил, талбайн хэмжээг тодорхойлж, | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | **Жилийн эцэст:** Нөхөн сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах, | Байгаль орчны менежмент төлөвлөөгөөгөөр “маш хүчтэй доройтсон” дүгнэлт гарсан ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 17 аж ахуйн нэгжийн ашиглалт явуулсан талбайг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ажилд тусган, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийлгүүлэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах | | | | хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. | ажлыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран зохион байгуулсан бөгөөд техникийн нөхөн сэргээлт хийсэн 11 талбайн 121.93 га, биологийн нөхөн сэргээлт хийсэн 8 талбайн 71.1 га, эвдэрч орхигдсон 805.20 га талбай буюу нийт 998.23 га талбайд 31,718,388.910 төгрөгийн хөрөнгөөр нөхөн сэргээлт хийгдсэнийг хүлээн авч ажилласан байна. | |
| 1.7.2.2 | Аймгийн хэмжээнд хийгдсэн хот, тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажил болон төлөвлөгөөт хянан баталгааны ажлуудын тайлан, тоон мэдээллийг нэгтгэж, Газрын мониторингийн цахим системд оруулах | Үйл ажиллагаа | Цахим системд оруулсан тоон мэдээлэл | - | **Жилийн эцэст:** Мэдээллийн санг Газрын мониторингийн цахим системд оруулсан байна. | Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 633 нэгж талбарын газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан, тоон мэдээллийг стандартын дагуу нэгтгэж, газрын мониторингийн цахим системд оруулж ажилласан. | 100 |
| 1.7.2.3 | Газар хамгаалах, нөхөн сэргээх зардлын зах зээлийн үнийн судалгаа хийх | Үйл ажиллагаа | Судалгаа-1 | - | **Эхний хагас жилд:** Газрын нөхөн сэргээлтийн ажлын үе шатыг нарийвчлан тодорхойлж, нөхөн сэргээлт хийгдэхэд шаардагдсан зардлын мэдээллийг цуглуулж, задаргааг тооцсон судалгааг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Газар хамгаалах, нөхөн сэргээх зардлын зах зээлийн үнийн судалгааг холбогдох байгууллагуудаас авахаар хүсэлтийг хүргүүлсний дагуу 3 суманд техникийн болон биологийн нөхөн сэргээлтээр 2950,54 га газрыг 17,732 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр нөхөн сэргээсэн үнийг тооцсон мэдээллийг цуглуулж, үнийн задаргааг тооцсон судалгааг 2024 оны 01/228 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| **1.7.3** | **Мониторингийн системд зайнаас тандан судлалын** | **Урсгал төсөв** | **Суурь зургууд гарсан байна.** | **2020 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс Газрын мониторингийн** | **Мониторингийн системд зайнаас тандан судлалын арга, технологийг** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **арга, технологийг нэвтрүүлэх** | | | **системийг хэрэглээнд нэвтрүүлсэн.** | **ашиглах нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.** | | |
| 1.7.3.1 | Газрын мониторингийн үйл ажиллагаанд зайнаас тандан судлалын арга, технологийг ашиглан, газрын бүрхэвчийн өөрчлөлт, доройтол, элгэдэл, эвдрэл, бэлчээрийн газрын даац, чадавхыг тодорхойлох | Үйл ажиллагаа | Ирүүлсэн тайлангийн тоо | БХБС-ын 2022 оны 126 дугаар тушаалаар “Зайнаас тандан судлалын аргаар бэлчээрийн газрын мониторинг хийх аргачилсан заавар” батлагдсан. | **Жилийн эцэст:** Газрын даамал, мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж, хиймэл дагуулын 6-9 дүгээр сарын мэдээнд үндэслэн сум тус бүрээр ургамлын бүрхэвчийн зураглалыг хийж, бэлчээрийн газрын биомасс, даацыг тооцон аймгийн хэмжээнд элгэдэл, эвдрэл, доройтолд өртсөн газрыг тодорхойлж, үр дүнг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Mongolian data cube цахим порталаас Landsat-8 OLI/TIRS хиймэл дагуулын мэдээнээс 2023 оны 6 дугаар сарын 10, 7 дугаар сарын 10, 8 дугаар сарын 10-ны 11 сувгийн мэдээ бүхий 9 планшэйтийн Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрийг багтаасан растер мэдээг болон 2024 оны мөн саруудын мэдээг татаж, ургамалжилтын индекс болох NDVI–г бодуулан 2023, 2024 оны ургамалжилтын харьцуулсан зургийг хийж, үр дүн тайланг suurisudalgaamonitoring@gmail.com цахим хуудас руу илгээж ажилласан. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.8.** **Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.** | | | | | | | |
| **1.8.1** | **Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Улсын хэмжээний тайлан** | **2018 онд Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулсан.** | **Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, явцыг жил бүр Засгийн газарт танилцуулсан байна.** | | |
| 1.8.1.1 | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг | Үйл ажиллагаа | Хэрэгжилтийн тайлан-1 | Засгийн газрын 2018 оны 384-р тогтоолоор Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:** Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний 2023 оны хэрэгжилтийг 1-р | Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 2023 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр ГЗБГЗЗЕГ-т | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | | | | улиралд багтаан гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | otgonchimeg.r@gazar.gov.mn хаягаар хүргүүлсэн. | |
| **1.8.3** | **Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **8 аймгийн болон нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө** | **12 аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.** | **Шинэчлэн боловсруулсан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг холбогдох аймгуудад хүргүүлсэн байна.** | | |
| 1.8.3.1 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | Хэрэгжсэн арга хэмжээний тоо | 18 аймгийн ГЗБЕТ (Говьсүмбэр, Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ) боловсруулсан. | **Жилийн эцэст:** Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулсан байна. Хэрэгжилтийг 12 дугаар сарын 20-ны дотор тайлагнасан байна. | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийг гүйцэтгэгч байгууллагаас 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр хүлээлгэн өгсөн бөгөөд уг төлөвлөгөөний дагуу аймгийн хөгжлийн алс хэтийн бодлогыг харилцан уялдаатайгаар боловсруулан хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяа агентлагууд болон 17 сумын Засаг дарга нарт үүрэг болгон, баримт бичгийг албан ёсоор хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан. Мөн уг төлөвлөгөөг 64 арга хэмжээний хүрээнд 5 жилийн давтамжтайгаар 3 үе шатанд хуваах хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2024-2028 он хүртэлх 25 ажил арга хэмжээг төлөвлөснөөс энэ онд 10 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, хэрэгжүүлсэн ажлын талаарх тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. | 100 |
| 1.8.3.2 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй | Үйл ажиллагаа | Судалгаа, мэдээллийн тоо | 18 аймгийн ГЗБЕТ (Говьсүмбэр, Увс, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Булган, | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй | Аймгийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан 17 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 17 сумын Засаг дарга нарт 2 боть ном, төлөвлөлтийн зураг, файлыг тоон хэлбэрээр тус бүр 2 хувийг хүлээлгэн өгөв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбоотой мэдээ, судалгааг холбогдох байгууллагад хүргүүлэх | | | Баянхонгор, Орхон, Архангай, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ) боловсруулсан. 175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулагдсан. | холбоотой мэдээлэл, судалгааг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Мөн аймгийн ерөнхий төлөвлөгөө болон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний 2024 оны биелэлтийг гарган ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. | |
| **1.8.4** | **Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах** | **Орон нутгийн төсөв** | **16 сум** | **98 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, баталгаажуулсан.** | **Жил бүр 18 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.** | | |
| 1.8.4.1 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах. | Үйл ажиллагаа | Хэрэгжсэн арга хэмжээний тоо | Улсын хэмжээнд 175 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө батлагдсан. | **Жилийн эцэст:** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж, цахим системд байршуулсан байна. Хэрэгжилтийг 2024 оны 12 дугаар сард багтаан тайлагнасан байна. | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан сумдууд 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд Засгийн газрын 2024 оны 136, 74 дүгээр тогтоолын дагуу 223 нэгж талбар бүхий 2280,48 га газрыг эзэмшүүлсэн. Мөн уг төлөвлөгөөтэй уялдуулан малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар 6 суманд 33 нэгж талбар бүхий 319,87 га газрыг олгохоор төлөвлөн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тодотгол оруулж, 12 нэгж талбар бүхий 45,2 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар олгосон бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн ажилласан. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.9.**<br>**Мэдлэгт суурилсан, иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн системийг бий болгоно.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.9.1** | **Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг нийгэм, эдийн засаг, хүн амын өсөлт, байгалийн нөхцөл, нөөцийн чадавхид нийцүүлэн оновчтой зохион байгуулах, хуваарилах** | **Үйл ажиллагаа** | **Аймаг бүрээр боловсруулсан санал** | **21 аймаг, 330 сумын хилийн цэсийг тодотгосон.** | **Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг боловсронгуй болгох саналыг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.** | | |
| 1.9.1.1 | Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 24 дүгээр тушаалаар байгуулагдсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн маргааныг шийдвэрлэх талаар санал, дүгнэлтийг гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг"-ээс гаргасан дүгнэлтийн дагуу орон нутгийн удирдлагууд, иргэд, олон нийтэд хилийн цэсийн талаарх үнэн зөв мэдээллийг өгөх ажлыг зохион байгуулж, тайлан, мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Тайлан хүргүүлсэн байдал | Бүх сумдын хилийн цэсийг тодотгосон. | Орон нутгийн удирдлагууд, иргэд, олон нийтэд хилийн цэсийн талаарх үнэн зөв мэдээллийг өгөх ажлыг зохион байгуулж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна | Хилийн цэсийн маргааныг бууруулах ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн, Сант сумдын удирдлагууд болон иргэдийг хилийн цэс баталсан тухай зарлиг тогтоомжийн архивын мэдээллээр ханган ажилласан. Мөн Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Дархан-Уул аймгийн Хонгор сумын хооронд үүссэн хилийн цэсийн маргаантай холбоотойгоор Дархан-Уул аймгийн сум дундын ойн ангийн нэхэмжлэлтэй, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Засаг даргад тус тус холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хилийн цэсийн маргаантай холбоотой нотлох баримтыг нотлох баримтын шаардлага хангуулан Сэлэнгэ аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлсэн. Дээрх маргаантай холбоотойгоор эцэслэсэн шийдвэр эрх бүхий субъектээс гараагүй байна. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.13.<br>Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих** | | | | | | | |
| **1.13.2** | **Салбарын үйл ажиллагаанд цахим гарын үсэг болон тоон гарын үсэг нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа** | **85 тоон гарын үсэг** | **Салбарын хэмжээнд нийт 649 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон.** | **Газрын харилцааны салбарын нийт албан хаагчид тоон гарын үсэг** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **ашигладаг болсон байна.** | | |
| 1.13.2.1 | Тоон гарын үсгийн олголт хийх, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах боломжийг нэвтрүүлэх | Үйл ажиллагаа | - Тоон гарын үсэг эзэмшигчийн тоо<br>- Тоон гарын үсгийг ашиглаж буй үйл ажиллагааны тоо | Салбарын хэмжээнд нийт 649 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон. | - Тоон гарын үсгийн олголтыг шинэчлэн хийсэн байна.<br>- Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна. | Тайлант хугацаанд ГЗБГЗЗЕГ-аас ирүүлсэн нийт 26 ширхэг тоон гарын үсгийн токен төхөөрөмжийг аймаг, сум тус бүрээр сериал дугаар болон нэрсийн жагсаалт, бүртгэлийн судалгаар гаргаж, газрын даамлуудын нэр солиулах, тоон гарын үсгийн сунгалтын ажлыг гүйцэтгүүлэхээр ГЗБГЗЗЕГ-ын Орон зайн мэдээлэл технологийн хэлтэст 2024.04.24-ний өдөр 192.168.20.24 серверээр дамжуулан хүсэлтийг хүргүүлж ажиллалаа. Мөн тоон гарын үсгийн технологийг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж, мэргэжилтэн болон сумдын газрын даамлууд нийт 26 тоон гарын үсгийг өдөр тутмын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байна. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.14.<br>Төрийн архивын стандарт орчныг сайжруулах** | | | | | | | |
| **1.14.1** | **Төрийн архивыг цахимжуулах, цахим мэдээллийн сан бүрдүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа** | **1764 хадгаламжийн нэгж** | **2022 онд Төрийн архивын 14879 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбосон.** | **1764 хадгаламжийн нэгжийн баримтыг архивын цахим системд холбоно.** | | |
| 1.14.1.1 | Архивын баримтыг цахимжуулах, цахим мэдээллийн сан үүсгэх | Үйл ажиллагаа | Цахимжуул сан хадгаламжийн нэгжийн тоо | 2023 оны байдлаар 35 хадгаламжийн нэгжийн 8521 хуудас баримт цахимжсан. | **Жилийн эцэст:**<br>35 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагаар хангахад ГЗБГЗЗЕГ-ын Салбарын архивын хэлтэстэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна. | Тайлант оны жилийн эцсийн байдлаар байгууллагын архивын баримтыг цахимжуулах төлөвлөгөөний дагуу байнга хадгалах 10 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 1 хадгаламжийн нэгж, түр хадгалах 40 хадгаламжийн нэгж буюу нийт 51 хадгаламжийн нэгжийг үүсгэн материалыг тоон хэлбэрт шилжүүлж, ГЗБГЗЗЕГ-ын архивын програм, archive2.gazar.gov.mn цахим мэдээллийн санд шивж баяжуулалт хийсэн байна. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.15.** | | | | | | | |

| Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **1.15.1** | **Төрийн болон албаны нууцыг хадгалж хамгаалах, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Зохион байгуулсан ажлын тоо** | **-** | **Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах талаарх ажлуудыг зохион байгуулсан байна.** | | |
| 1.15.1.1 | Төрийн болон албаны нууцыг хадгалж, хамгаалах, хяналт тавих, Нууц албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 мэдээ,<br>1 тооллого | 2023 онд Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр явуулсан үйл ажиллагааны мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.<br>2023 онд Төрийн болон албаны нууцын тооллого хийж, дүн мэдээг хугацаанд нь явуулсан. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр 2024 онд хэрэгжүүлсэн ажлын мэдээг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор ТЕГ-ын орон нутаг дахь Тагнуулын газар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна.<br><br>Нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, нууц баримттай танилцах иргэний итгэмжлэлийг шинэчлэх, нууцын баталгаа авах, нотлох лавлагаа гаргаж өгөх, гадаад улсад зорчих эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтний урьдчилсан мэдүүлгийг авах, шилжилт хөдөлгөөний мэдээллийг тус тус бүртгэлжүүлж, мэдээ тайланг ТЕГ-ын орон нутаг дахь Тагнуулын газар, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | ГЗБГЗЗЕГ-ын даргын тушаалаар батлагдсан төрийн болон албаны нууцыг хамгаалах байгууллагын дотоод журмын хавсралтаар батлагдсан 24 маягтыг үндэслэн албан хэрэг хөтлөлттэй холбоотой 11 ширхэг бүртгэлийн дэвтрийг нээж, нууцын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд тайлант оны жилийн эцсийн байдлаар нийтдээ нууц баримт бичиг, нууц тээгчийн ирсэн бүртгэлд 5, явуулсан бүртгэлд 5 мэдээллийг тус тус бүртгэж баталгаажуулсан.<br>Мөн гадаад томилолтоор ажиллахаар хүсэлт ирүүлсэн 4 ажилтны явсан, ирсэн бүртгэлийг маягтаар бөглүүлэн холбогдох мэдээллийг Сэлэнгэ аймаг дахь Тагнуулын газарт хүргүүлэн ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Аймгийн ГХБХБГ-ын төрийн болон албаны нууцын хадгалалт хамгаалалтын үзлэг тооллого хийсэн байна.<br>Тооллогын мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.20.**<br>**Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглалтанд оруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.** | | | | | | | |
| **1.20.1** | **Инженерийн дэд бүтэцтэй холбоотой мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх** | **Үйл ажиллагаа** | **Инженерийн дэд бүтцийн мэдээлэл** | **-** | **Төлөвлөлтийн инженерийн дэд бүтэц, бэлтгэл ажлын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэсэн байна.** | | |
| 1.20.1.1 | Инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний орон зайн тоон зургийг холбогдох хангагч, ашиглалт хариуцсан байгууллагатай хамтран баяжилт хийх, мэдээллийг Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөлтийн 7 давхаргын мэдээлэл | - | Аймгийн хэмжээнд Хот байгуулалтын кадастрын системд төлөвлөлтийн 7 давхаргын мэдээллийг бүртгэсэн байна. | Шинээр ашиглалтад орсон инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийн хэмжилтийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, актаар баталгаажуулан мэдээллийн санд бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Тайлант хугацаанд 49 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн зургийг хүлээн авч баталгаажуулсан.<br>Мөн “Сэлэнгэ энерго” ОНӨААТҮГ нь Сүхбаатар сумын төвд хийгдэх 6км орчим дулааны шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг геодезийн хэмжилт хийх эрх бүхий байгууллага “Сэлэнгэ тулга ХХК”-аар гүйцэтгүүлсэн бөгөөд нэгдсэн шугам сүлжээний зурагтай тулгалт хийх ажил хийгдэж байна. | 100 |
| **1.20.2** | **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг** | **Үйл ажиллагаа** | **2 арга хэмжээг авч хэрэгжүүлэх** | **-** | **Хот байгуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **танилцуулах, сурталчлах** | | | | **системийг сурталчилсан байна.** | | |
| 1.20.2.1 | Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах | Үйл ажиллагаа | 4 арга хэмжээ | - | **Жилийн эцэст:**<br>Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлсэн байна. | Хот байгуулалтын кадастрын цахим системийг олон нийтэд сурталчлах зорилгоор www.selenge.gazar.gov.mn вэб хуудас, Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар фэйсбүүк хуудсуудаар дамжуулан мэдээ, мэдээллийг хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 58 аж ахуйн нэгж, иргэдэд Хот байгуулалтын кадастрын цахим системээр дамжуулан хэрхэн хүсэлт явуулах талаар гарын авлага, тараах материал болон заавар зөвлөгөөг өгч ажиллав.<br>Мөн 2024.11.14-ний өдөр Сүхбаатар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөд Хот байгуулалтын цахим системийн талаар, ажил эхлүүлэх зөвшөөрөл хэрхэн илгээх, ямар үе шат дамждаг талаарх мэдээ мэдээллийг тус тус өгсөн. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.21.<br>Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.** | | | | | | | |
| **1.21.1** | **Аймгийн хэмжээнд газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хяналт шалгалт хийх** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжилтийн хувь** | **-** | **Газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон газрын төлөв байдал, чанарын хянан магадлагааны хэрэгжилтийг 80%-д хүргэсэн байна.** | | |
| 1.21.1.1 | Аймгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 15 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, | - Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 576 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр “Хяналт шалгалтын төлөвлөгөөг” Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор батлуулсан. | Шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна.<br>Хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. | Тайлант хугацаанд Баянгол сумын “Хүрэл өлзий” ХХК, “Шанддов” ХХК, Жавхлант сумын “Өгөөж андууд” ХХК, Моностойн нуруу ХХК, Бүрэн Сэлэнгэ монос ХХК, Бүрэн Сэлэнгэ ХХК болон Баруунбүрэн, Баянгол, Сант сумдын Газрын даамлын үйл ажиллагаанд тус тус төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | - Барилга, хот байгуулалтын Сайдын 2023 оны 74 дүгээр тушаалаар батлуулсан. | Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Барилгын техникийн хяналтын улсын байцаагчтай хамтарсан хяналт шалгалтыг Сүхбаатар сумын “Халада” ХХК, “Экстракт” ХХК, Мандал сумын “Авга тайж констракшн” ХХК-уудад хийж гүйцэтгэн хамтарсан албан шаардлагыг хүргүүлсэн. Дээрх шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд улсын байцаагчийн болон хамтарсан 26 заалт бүхий 7 албан шаардлагыг хугацаатай өгч, биелэлтийг тооцон ажиллаж байна. Зөрчилтэй байсан 4 аж ахуй нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу тус бүр 300.000 төгрөг буюу нийт 1,200,000 төгрөгийн торгуулийг оногдуулж төлбөрийг 100% барагдуулж ажиллалаа. | |
| 1.21.1.2 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх. | Үйл ажиллагаа | Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо, гүйцэтгэлийн хувь,<br><br>хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт | Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийх, дүгнэлт гаргах, авах арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу цахим системд үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн. | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Шалгалтын дүнг хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 35-00/08 удирдамжийн дагуу Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтад аймгийн хэмжээнд сумдын газрын даамлуудыг хамруулсан. Сэлэнгэ аймгийн хэмжээнд нэгж талбарын цахим хувийн хэрэгтэй холбогдсон өргөдлөөс 1120 буюу 8.5 хувьд нэгж талбарын цахим хувийн хэргийн баримт, материал (нотлох баримт), мэдээллийг холбогдох журмын дагуу оруулсан эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар сумдын Газрын даамлуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж байна. | 100 |
| 1.21.1.3 | Тусгай зөвшөөрөлтэй болон мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын баталсан 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 35-00/12 дугаартай “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | | арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | | Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | дагуу Сэлэнгэ аймагт Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх болон газрын төлөв байдал чанарын хянан баталгаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байгаа 4 аж ахуйн нэгжийг хамруулсан. Шалгалтыг 35.5 кодтой “Геодези зураг зүйн үйл ажиллагааг шалгах” хяналтын хуудсаар шалгахад “Сэлэнгэ тулга” ХХК нь 26%-бага эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт-70%, “Лэнд луужин” ХХК нь 41%-дунд эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт-67%, “Эхлэх цэг хангай” ХХК нь нь 20%-бага эрсдэлтэй, хууль сахин мөрдөлт-75% үнэлэгдлээ. “Ленд меп” ХХК нь газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааг хийж гүйцэтгэж байна. | |
| 1.21.1.4 | Соёл, урлагийн байгууллагын газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлж, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | ГЗБГЗЗЕГ-ын салбарын улсын ерөнхий байцаагч, Соёлын салбарын улсын ерөнхий байцаагчийн хамтран баталсан урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 35-00/06 дугаартай удирдамжийн хүрээнд аймгийн хэмжээнд нийт 27 соёл урлагийн байгууллагыг шалгалтад хамруулсан. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт 7 заалттай албан шаардлагыг хүргүүлж, биелэлтийг тооцон ажиллаж байна. Удирдамжийн хавсралт хүснэгтийн дагуу аймгийн хэмжээний 29 соёл урлагийн байгууллага, Засгийн газрын 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан Улсын хамгаалалтын зэрэглэлд байх, 3 түүх соёлын үл хөдлөх дурсгалуудын дэлгэрэнгүй бүртгэл жагсаалтыг гарган, танилцуулгын хамт ГЗБГЗЗЕГ-ын Салбарын хяналт шалгалтын хэлтсийн ахлах мэргэжилтэнд хүргүүлсэн. | 100 |
| 1.21.1.5 | Газрын нэгдмэл сангийн удирдлагын | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд | Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 35- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшил, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах | | объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | | хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | 00/08 удирдамжийн дагуу Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд зөрчилтэй бүртгэгдсэн иргэн, хуулийн этгээдийн газар эзэмшил, ашиглалтын байдалд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар сумдын Газрын даамлуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллаж байна. Цахим системд зөрчилтэй оруулсан мэдээллийг засаж шинэчлэх ажил нь системийн эрхтэй холбоотой удаашралтай байгаа тул зарим албан хаагчдад мэдээлэл оруулах эрхийг нээж өгөх, талаарх саналыг дээд шатны байгууллагад уламжилсны дагуу Баянгол, Сайхан сумдад мэдээлэл засварлах эрхийг олгосон бөгөөд зөрчлийг засварлан ажиллаж байна. | |
| 1.21.1.6 | Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн нэгж талбарын цахим системд үүсгэсэн хувийн хэргийн бүрдүүлэлтэд гүйцэтгэлийн хяналт хийх | Үйл ажиллагаа | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан объектын тоо | 2023 онд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн “Газрын кадастрын цахим систем”-д нэгж талбарын цахим хувийн хэргийн бүрдүүлэлтэд хяналт хийх, дүгнэлт гаргах, авах арга хэмжээний саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу цахим системд үүсгэсэн хувийн хэргийн 1.2 хувь буюу 13,501 нэгж талбарын хувийн бүрдүүлэлтэд хяналт хийсэн. | **Эхний хагас жилд:** Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 04 дүгээр захирамжаар “Монгол Улсын газрын нэгдмэл сан, газар ашиглалт, бүртгэл, түүний хяналтын үйл ажиллагааг шалгаж, холбогдох арга хэмжээг хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд уг шийдвэрийн дагуу ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/17 дугаар тушаалаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Сайхан сумдын иргэн, хуулийн этгээдэд 2003-2023 оны хооронд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгосон сумын Засаг даргын захирамж, нэгж талбарын хувийн хэрэгт авагдсан баримт, материалын бүрдэл, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичиг, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын материалын бүрдэл болон уг хугацаанд мөрдөгдөж байсан Газрын үнэлгээний бүс, хил хязгаарыг баталсан ИТХ-ын тогтоол, шийдвэрийг хэрхэн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан эсэхэд мөн аймгийн хэмжээнд 17 сумын 450 цахим хувийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэргийг түүвэрлэн шалгаж хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтаар хувийн хэргийн буруу материал оруулсан 6, хоосон цаас оруулсан 3, шаардлага хангаагүй сканердсан файл 2 буюу, нийт зөрүүтэй материал илгээсэн тохиолдлыг илрүүлсэн байсан байна. ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 1/2322 тоот албан бичгийн дагуу аймгийн хэмжээнд цахим хувийн хэргийг шалгаж дуусган, шалгалтын тайлан танилцуулгыг хүргүүлэхээр ажиллаж байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.22.<br>Хүн амын нутагшилт, суурьшлийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.** | | | | | | | |
| **1.22.2** | **Захиргааны чиглэлээр эрх зүйн актуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох** | **Үйл ажиллагаа** | **Жил бүр 5-аас доошгүй эрх зүйн акт** | **Жил бүр 10 орчим эрх зүйн акт боловсруулж байна.** | **Нийт эрх зүйн актын 10 орчим хувийг шинэчилсэн байна.** | | |
| 1.22.2.1 | Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгөх | Үйл ажиллагаа | Санал өгсөн төслийн тоо | 2022 онд улсын хэмжээнд 6 норм, дүрэм, 5 стандарт, 12 журам, 3 зааварт санал өгсөн. | Нийтээр болон салбарын хэмжээнд дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын төсөлд санал өгсөн байна. | - Тайлант онд “Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журам”, “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын өөрчлөлтөд оруулах саналыг тус тус Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүргүүлсэн. Мөн Газрын удирдлагын нэгдсэн системийн программ хангамжийн хөгжүүлэлтийн 2025 оны саналыг 2024 оны 02/407 тоот албан бичгээр хүргүүлж ажиллав.<br>- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас боловсруулсан “Аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын төсөлд 2024.07.01-ний өдрийн 01/235 тоот албан бичгээр санал хүргүүлэв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.22.2.2 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийн үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | Эрсдэлийн үнэлгээг үнэлсэн байдал | 2023 онд улсын хэмжээнд 7035 объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн. | **Жилийн эцэст:** Эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийг үнэлэх ажлыг зохион байгуулсан байна. | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр объектын эрсдэлийн үнэлгээг хийх шилэн хяналтын цахим систем устаж, шинээр 2024 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс ашиглагдах болж, 2024 онд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх шалгалтад хамрагдсан объектуудыг бүртгэн шивж оруулж байна. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, төлөвлөх ажлын хүрээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр 335 объектын эрсдэлийн үнэлгээг хийсэн. | 100 |
| 2.1.13.1 | Архивын хадгаламжийн санг зориулалтын шүүгээ, тавиур, техник, | Үйл ажиллагаа | Саналын тоо | Жил бүр архивын стандарт орчныг бүрдүүлэх арга хэмжээг зохион байгуулдаг. | **Жилийн эцэст:** Шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр | Архивын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай стандарт орчныг бүрдүүлэх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох зардлын тооцоог гарган | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах талаар санал тавьж шийдвэрлүүлэх | | | | хангах арга хэмжээ авсан байна. | удирдлагад танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.<br>Байгууллага зориулалтын архивын өрөөгүй хадгаламжийн нэгжийг төмөр сейфэнд хадгалдаг тул зориулалтын шүүгээг шийдвэрлүүлэх саналыг дээд шатны байгууллагад 2024.04.23-ны өдрийн 03/129 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Архивын өрөөнд галын хор, гал унтраах механик төхөөрөмж, агааржуулагч, чийгшүүлэгч, чийг дулаан хэмжигч, компьютер, түргэн сканер, принтер, цаас хэрчигч, үдэгч машин, цахилгаан өрөм, хайч, шөвөг, хавчаар, термометр зэргийг байршуулсан. | |
| **2.1.14** | **Геодезийн хэмжилтийн багаж баталгаажуулалтын лабораторийн үйл ажиллагааг сайжруулах** | **Үйл ажиллагаа** | **Баталгаажуулсан багажны тоо** | **2022 онд улсын хэмжээнд 2325 багаж баталгаажуулсан.** | **2023 онд улсын хэмжээнд 1540 багажийг баталгаажуулсан байна.** | | |
| 2.1.14.1 | Аймгийн ГХБХБГ-т хэрэглэж буй геодезийн хэмжлийн багажийг баталгаажуулах | Үйл ажиллагаа | 3 багаж | 2023 онд аймгийн ГХБХБГ-т хэрэглэж байгаа нийт 3 багаж баталгаажуулалт хийлгэсэн. | 2023 онд баталгаажуулалт хийлгэсэн хугацаанд, бүх багажуудыг бүрэн хамруулсан байна. | Байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж буй Trimble r4 маркийн 2 долгионы GPS-ийг ГЗБГЗЗЕГ-ын хэмжилтийн жишилтийн полигонд хэмжилт хийн лабораториор баталгаажуулж, 2024 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр 0031107, 0031108, 0031109 дугаартай гэрчилгээнүүдийг авсан. | 100 |
| 2.1.15 | **Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах** | **Үйл ажиллагаа** | **Иргэн, хуулийн этгээдийн тоо** | | **Эрсдэл үүсэх магадлалыг бууруулсан байна** | | |
| 2.1.15.1 | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөт бус шалгалт хийсэн объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, гомдлыг хүлээн авч төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, Сүхбаатар сумын “Гүнж аялгуу” ХХК-ийн газар ашиглалтын байдалд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж зөрчлийг арилгуулахаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | 35-29-01/041/01 дугаартай улсын байцаагчийн албан шаардлагыг 5 хоногийн хугацаатай хүргүүлж, хугацаанд нь зөрчлийг арилгуулсан. Алтанбулаг суманд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг улсын ахлах байцаагчтай хамтран хийж гүйцэтгэн 35-29-01/041/01 дугаартай улсын байцаагчийн 1 дүгнэлтийг өгч ажиллалаа. | |
| 2.1.15.2 | Эрх бүхий байгууллага, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Төлөвлөгөөт бус шалгалт хийсэн объектын тоо | - | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна. Эрх бүхий байгууллага, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Цагааннуур, Алтанбулаг, Жавхлант, Орхонтуул, Хушаат, Сүхбаатар сумдын Засаг дарга нараас ирүүлсэн хүсэлт, удирдлагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, Геодезийн асуудал хариуцсан мэргэжилтний хийсэн хяналтын хэмжилтийн зураг, гэрээг дүгнэсэн актыг үндэслэн 2024.06.03-ны өдрийн 01/205, 01/207 дугаар албан бичгээр Засаг дарга нарт хариуг нь хүргүүлсэн. Илэрсэн зөрчилд нь шийтгэлийн арга хэмжээ оногдуулж, зөрчил арилгуулахаар албан даалгавар өгч ажиллалаа. | 100 |
| 2.1.15.3 | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авах | Үйл ажиллагаа | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээ авч | - | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн дагуу арга хэмжээг авсан байна. | 2024 онд аймгийн хэмжээнд иргэн, аж ахуй нэгж, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 43 зөрчлийн талаарх гомдол мэдээллийг нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, 2 иргэн, аж ахуйн нэгжид холбогдох зөрчлийн хэргийн нээж, 41 иргэн, аж ахуйн нэгжийн зөрчилд “Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа” явуулж, Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 10.1, 10.5 дэх заалт, 8.2 дугаар зүйлийн 8.2.1, 8.2.2 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлсэн тоо | | | дахь заалт, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалтуудыг үндэслэн 6 аж ахуйн нэгжид 6,500,000 төгрөгийн шийтгэл, 29 иргэнд 3,060,000 төгрөгийн шийтгэлийг тус тус оногдуулж, төлбөрийг 100% барагдуулж ажиллалаа. Мөн 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн хэрэг нээж 97 сая төгрөгийн шийтгэл, нөхөн төлбөр оногдуулсан боловч хүлээн зөвшөөрөхгүй анхан шатны шүүхэд саналаа хүргүүлсэн бөгөөд эцсийн шийдвэр гаргаагүй байна. | |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.1<br>Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ.** | | | | | | | |
| **3.1.1** | **Газар зүйн нэрийн тодруулалт** | **Улсын болон орон нутгийн төсөв** | **Нэрийн тодруулалт хийх аймаг, сумын тоо** | **2023 онд 11 аймгийн 35 сум, нийслэлийн 1 дүүрэг газар зүйн нэрийн тодруулалтын ажил хийсэн.** | **Нэрийн тодруулалт хийх ажлын төсөв батлагдсан аймаг, сумын газар зүйн нэрийн тодруулалт хийгдэж, мэдээллийн сан байгуулна.** | | |
| 3.1.1.2 | Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах | Урсгал төсөв | 2 хурал | 2023 оны Газар зүйн нэрийн зөвлөлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. 4 удаа газар зүйн нэрийн зөвлөлийн хурлыг зохион байгуулсан. | **Жилийн эцэст:** Газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, хурлын тэмдэглэлийг баталгаажуулан ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Сэлэнгэ аймгийн Ерөө болон Зүүнбүрэн сумдын “Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил”-ын даалгаврыг батлуулан, гүйцэтгэгч байгууллагаас үнийн саналыг авч, гэрээ байгуулахаар ажиллаж байна. Мөн 17 сумын газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлын 567.000.877 төгрөгийг 2025 оны орон нутгийн төсөвт тусгуулахаар саналаа аймгийн Засаг даргад 01/399 тоот албан бичгээр хүргүүлж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан.<br>Сэлэнгэ аймгийн Газар зүйн нэрийн салбар зөвлөл нь 2024 оны 05 сарын 12-нд хуралдсан бөгөөд холбогдох тайланг 2024 оны 05 дугаар сард багтаан ГЗБГЗЗЕГ-ын Геодези, зураг зүйн хэлтэст цахимаар хүргүүлсэн. | |
| **3.1.3** | **Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Бэлчээрийн фото мониторингийн 5166 цэг** | **2022 онд Бэлчээрийн фото мониторингийн 5166 цэгт бэлчээрийн фотомониторингийн ажлыг зохион байгуулсан.** | **Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг нийслэлийн 6 дүүрэг, 21 аймгийн 320 сумын хэмжээнд бэлчээрийн газрын 5166 мониторингийн цэгт хийсэн байна.** | | |
| 3.1.3.1 | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах | Үйл ажиллагаа | Аймгийн хэмжээнд байгуулсан мониторингийн цэгийн тоо | 2023 онд 21 аймаг, нийслэлийн 6 дүүргийн бэлчээрийн газарт фото мониторингийн ажлыг зохион байгуулагдсан. | **Жилийн эцэст:**<br>2024 оны бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан нэгтгэж, холбогдох зөвлөмжийг гаргаж, газрын мониторингийн цахим системд бүрэн оруулж, тайланг 10 сарын 01-ны дотор хүргүүлсэн байна. | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд нийт 17 сумын 108 фотомониторингийн цэгт хээрийн хэмжилт, зураглалыг хийж, боловсруулалтыг Sample point” программ дээр хийж гүйцэтгэн, тайланг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэн ажилласан.<br>Сэлэнгэ аймгийн хувьд тариалангийн бүс нутаг учраас бэлчээрийн талбай жилээс жилд багасаж байгаа нь бэлчээрийн одоо байгаа даац хэтрэх төлөвтэй байна. Мал бэлчих хоногоор нь авч үзэхэд Сэлэнгэ аймгийн хэмжээнд жилийн дөрвөн улирлаар ашигладаг бэлчээр нийт талбайн ихэнх хувийг эзэлж байна. Иймд тариалангийн бүс нутгийг малын тоо толгойг боломжит хэмжээнд хүртэл багасгах төрийн зохион байгуулалт шаардлагатай талаарх санал дүгнэлтийг тайланд тусган хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.3.2 | Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журам, арга зүйг сайжруулах талаар санал боловсруулах | Үйл ажиллагаа | Санал-1 | Газрын даргын 2015 оны А/105 дугаар тушаалаар “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх журам” батлагдсан. | Зайнаас тандан судлалын аргуудын талаар мэдээлэл цуглуулж, фото мониторингийн арга зүйн дутагдалтай болон давхардалд дүн шинжилгээ хийж, алдаа дутагдал, сайжруулах талаар Газрын даамлуудаас судалгаа авч, нэгтгэн ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Газрын даамлууд бэлчээрийн ургацыг тогтооход хүндрэлтэй бөгөөд ургацын хэмжээ бодит бус гардаг иймд зайнаас тандан судлах аргуудын нэг болох “Sentinel” хиймэл дагуулын тоон өгөгдлийг ашиглах, түүнийг өргөн хүрээнд хэрэглээнд нэвтрүүлэх мөн фото мониторингийн аргаар зураг боловсруулахад 5-аас илүүгүй зураг дээр боловсруулалт хийх байдлаар механик ажиллагааг багасгах, газрын даамлуудад үе шаттай сургалт зохион байгуулж чадавхжуулах шаардлагатай талаарх судалгааг авч саналыг, ГЗБГЗЗЕГ-ын Суурь судалгаа, мониторингийн хэлтэст 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлсэн. | 100 |
| 3.1.3.3 | Бэлчээрийн фото мониторингийн багаж хэрэгслийг шинэчлэх шаардлагатай сумдын судалгааг гаргах, мөн багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Багаж, хэрэгслийн тоо | - | **Эхний хагас жилд:** Бэлчээрийн фото мониторингийн багаж хэрэгслийг шинэчлэх судалгааг гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлж, багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулсан байна. | Бэлчээрийн фото мониторингийн багаж хэрэгслийг шинэчлэх судалгааг гарган, мэргэжлийн компаниудаас үнийн санал авч, ГЗБГЗЗЕГ-ын Суурь судалгаа мониторингийн хэлтэст хүргүүлсэн, жилийн эцсийн байдлаар шинэ багаж хэрэгслээр хангагдаагүй байна. | 70 |
| **3.1.4** | **Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах** | **Үйл ажиллагаа** | **Төлөвлөгөөт болон захиалгат хянан баталгаа хийгдсэн тоо** | **Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийсэн ажлын тайлан мэдээ** | **Газрын төлөв байдал чанарын хянан баталгаа хийх ажлыг зохион байгуулахад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж, хянан баталгааны үр дүнг мониторингийн цахим системд оруулсан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4.1 | Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийж, цахимаар болон хэвлэмэл байдлаар ирүүлсэн тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулах | Үйл ажиллагаа | Захиалгат хянан баталгаа хийж, баталгаажсан тайлан, дүгнэлтийн тоо | 2023 онд нийт 1455 тайлан, дүгнэлт баталгаажуулсан. | **Жилийн эцэст:** Цахимаар илгээсэн хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хянаж баталгаажуулсан байна. | Тайлант оны жилийн эцсийн байдлаар газрын мониторингийн цахим системээр газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны 643 ажлын тайлан, дүгнэлтийг хүлээн авч 633 тайлан, дүгнэлтийг байнгын шинжээчээр хянаж баталгаажуулан ажилласан байна. Баталгаажуулаагүй үлдсэн 10 захиалгат хянан баталгааг хянах шатандаа явж байгаа бөгөөд газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудсыг 60 иргэн, аж ахуйн нэгжид хэвлэн өгч ажилласан. | 100 |
| 3.1.4.3 | Атар газраас тариалангийн ангилалд шилжүүлэх саналыг судалж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санал, дүгнэлт боловсруулах. | Үйл ажиллагаа | Ирүүлсэн саналын тоо | ”Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг гаргаж, тус газрын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 1/1171 тоот албан бичгээр Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн. | **Жилийн эцэст:** Атар газрын ангилал шилжүүлэхээр холбогдох байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийг судлан шийдвэрлэсэн байна. | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд аймгийн хэмжээнд нийт 16 сумын 953 нэгж талбарын 19 мян.га талбайг газар тариалангийн зориулалтаар олгохоор төлөвлөсөн. Тайлант оны жилийн эцсийн байдлаар 51 нэгж талбарын 433,1 га газрыг олгосон. ГЗБГЗЗЕГ-ын 2024 оны 1/3078 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу бүх сумдын Засаг дарга нарт атар газрыг тариаланд шилжүүлэх санал ирүүлэх тухай 2024 оны 01/383 тоот албан бичгийг хүргүүлсэн бөгөөд 2024.12.03-ны байдлаар сумдаас санал ирээгүй байна. | 100 |
| **3.1.5** | **Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх** | **Үйл ажиллагаа** | **Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулсан төслийн тоо** | **21 аймгийн 330 сумын 2022 оны сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулсан байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн.** | **Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүрэн оруулж, хэрэгжилтэд хяналт системээр хяналт тавьж, шаардлагатай** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **арга хэмжээг зохион байгуулсан байна.** | | |
| 3.1.5.1 | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнах | Үйл ажиллагаа | Бүх сум | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжилт болон газар олголтын байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгаж тайлагнасан байна.<br>Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг 12 дугаар сарын 20-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай” 136 дугаар, “Монгол Улсын иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай” 137 дугаар, 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн “Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах зарим газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай” 74 дүгээр тогтоолуудаар нийт 201 нэгж талбар бүхий 37,13 га газрыг өмчлүүлэхээр, 1629 нэгж талбар бүхий 5657,6 га газрыг эзэмшүүлж, ашиглуулахаар тус тус баталсан. Энэхүү батлагдсан тогтоолын дагуу газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллах мөн Засгийн газрын тогтоолд тусгалдаагүй байршилд Газрын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийг зөрчиж газар олгохгүй байхыг нийт сумдын Засаг дарга, газрын даамлуудад 2024 оны 01/145, 01/146 тоот албан бичгээр чиглэл хүргүүлэн ажилласан бөгөөд батлагдсан тогтоолын дагуу 18 иргэнд 4,69 га газрыг өмчлүүлж, 674 нэгж талбар бүхий 3139,67 га газрыг эзэмшүүлж, ашиглуулсан байна. | 100 |
| 3.1.5.2 | Сумын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | 4 сургалт | - | Улиралд нэг удаа цахим болон танхимаар сургалт зохион байгуулсан байна.<br>Сургалт зохион байгуулсан тайлан | Тайлант хугацаанд сумын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>1. НҮБ-ын Хүнс, хөдөө, аж ахуйн байгууллага СТРИЙМ төслийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээг тухай бүр тайлагнасан байна. | санхүүжилтээр Ерөө, Жавхлант, Мандал сумдын “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-ний бодлогын бичиг баримтыг боловсруулан аймаг, суманд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан бөгөөд сумдын газрын даамлуудыг 1 өдрийн танхимын сургалтад хамруулав.<br>2. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуультай уялдуулан Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх талаарх цахим сургалтыг зохион байгуулж, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, Газрын даамлуудыг хамруулав.<br>3. Засгийн газрын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” 92 дугаар тогтоол, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-д орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх цахим сургалтад сумдын даамлуудыг хамруулав.<br>4. ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/253 “Ажлын хэсэг” байгуулан хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу захирамжийн бүртгэлтэй холбоотой Кадастрын хэлтсээс зохион байгуулсан сургалтад холбогдох мэргэжилтнүүд болон Газрын даамлуудыг хамруулав.<br>5. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд орсон өөрчлөлттэй холбоотой цахим сургалтуудад албан хаагчдыг бүрэн хамруулсан. Цахим сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгааг ГЗБГЗЗЕГ-ын Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.5.3 | Монгол улсын иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтын саналыг 2024 оны 3 дугаар улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 2025 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал | Жил бүр хийгддэг. | **Жилийн эцэст:** Иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг сум тус бүрээр гаргаж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Иргэнд 2025 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг аймгийн хэмжээнд нэгтгэн 652 нэгж талбар бүхий 227,22 га газрыг өмчлүүлэхээр Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн нэгдсэн системд нэгж талбар бүрээр төлөвлөн оруулсан бөгөөд аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна. | 100 |
| 3.1.5.4 | 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулах ажлыг зохион байгуулж, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг гарган хүргүүлэх | Үйл ажиллагаа | 2024 онд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал | - | **Жилийн эцэст:** Аймгийн хэмжээнд сумын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг 2024 оны 3-р улиралд багтаан баталгаажуулах ажлыг зохион байгуулж, тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг батлах тухай тогтоолын төсөлд тусгах саналаа 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” 92 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 3.24.8-д заасны дагуу сумдын 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төслийг хянан дүгнэлт гаргуулах хүсэлтийг 2024 оны 01/380 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэв. | 100 |
| **3.1.6** | **Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх** | **Үйл ажиллагаа** | **Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан Засгийн газрын тогтоол** | **Засгийн газрын тогтоолын дагуу улсын тусгай хэрэгцээнд авсан 3 газрын гэрээ гэрчилгээг олгох ажлын зохион байгуулсан.** | **Улсын тусгай хэрэгцээнд газрыг авах, гаргах асуудлын хэрэгцээ, шаардлагыг судлах, холбогдох судалгаа хийж, дүгнэлт** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **гаргаж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсэн байна.** | | |
| 3.1.6.1 | Байгалийн хий дамжуулах хоолой, түүнийг дагалдах барилга байгууламжууд баригдах газрыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн тогтоолын эх хувийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Аймгийн ИТХ-ын тогтоол | Засгийн газрын хуралдааны 2021 оны 55 дугаар тэмдэглэл гарсан. | **Эхний хагас жилд:** Байгалийн хий дамжуулах хоолой, түүнийг дагалдах барилга байгууламжууд баригдах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн, тогтоолын эх хувийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх хий дамжуулах хоолой, барилга байгууламж барих газрыг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, саналыг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлж ажилласан. | 100 |
| **3.1.7** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах** | **Үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн 2021 оны улсын нэгдсэн тайлан** | **Газрын нэгдмэл сангийн 2020 оны улсын нэгдсэн тайлан Засгийн газарт танилцуулагдсан.** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэлийн үйл ажиллагааг эрхэлж газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн бүртгэгдсэн байна.** | | |
| 3.1.7.1 | Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг сумдаас авч нэгтгэн, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайлан | Газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | **Жилийн эцэст:** Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг хуульд заасан хугацаанд хүлээн авч нэгтгэн, дараа оны 01 сарын 15-ны өдрийн дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг 12 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон гаргаж 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд холбогдох тайланг нэгтгэн хуулийн хугацаанд багтаан хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.7.2 | Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээс гаргах ажлын хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн тайлан | - | **Жилийн эцэст:** Газрын нэгдмэл сангийн тайланг Газрын нэгдмэл сангийн мэдээллийн системээс гаргасан байна. | Сэлэнгэ аймгийн газрын нэгдмэл сангийн 2023 оны тайланг Засгийн газрын 2022 оны 432 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын нэгдмэл сангийн тайлан эрхлэх журам”-аар батлагдсан нэгдмэл сангийн тайлангийн ГНСТ-1 ээс ГНСТ-10 маягтуудаар гарган, холбогдох бусад судалгаа, тайлангуудын хамт Газрын нэгдмэл сангийн системээр дамжуулан хүргүүлж ажилласан. Мөн Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайланг 12 дугаар сарын 01-ний өдрөөр тасалбар болгон гаргаж 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх чиглэлийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд холбогдох тайланг нэгтгэн хуулийн хугацаанд багтаан хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна. | 100 |
| **3.1.9** | **Салбарын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах** | **Үйл ажиллагаа** | **30 ажил Баянзүрх дүүргийн нэгж талбарын хувийн хэрэг** | **2021 онд 65 ажлын бүрдлийг шалгаж акт үйлдэн хүлээн авсан. Налайх дүүргийн нэгж талбарын хувийн хэргийн баримтыг хүлээн авсан.** | **Төрийн архивт хүлээлгэн өгөхөөр ирүүлсэн 30 ажлыг шалгаж акт үйлдэн хүлээн авна. Баянзүрх дүүргийн 35543 нэгж талбарын хувийн хэргийн 678 хадгаламжийн нэгжийн баримтыг төрийн архивт хүлээн авсан байна.** | | |
| 3.1.9.1 | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивт ирүүлсэн ажлыг хүлээн авах | Үйл ажиллагаа | Үүсгэсэн хадгаламжийн нэгжийн тоо | 2023 онд 72 ажлын бүрдлийг шалгаж акт үйлдэн хүлээн авсан. | **Жилийн эцэст:** Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон гэрээт ажлын хүрээнд хийж төрийн архивт ирүүлсэн ажлыг хүлээн авч, данс бүртгэл үүсгэсэн байна. | Байгууллагын 2024 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт /ХХНЖ/”-ыг боловсруулж, ХХНЖ-аар нөхөн бүрдүүлэх хуваарь гарган БНШК-ын хурлаар батлуулсан. 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан хаагчдын хөтөлж дууссан баримт бичгийн бүрдлийг шалгаж байнга хадгалах хадгаламжийн нэгж, түр хадгалах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Архивт хадгалагдаж байгаа баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалт, өөрчлөлт, хөдөлгөөний мэдээлэл болон нэгж талбарын хувийн хэргийн судалгааг загварын дагуу гаргаж, 12 дугаар сарын 10-ны дотор ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах нийт 51 хадгаламжийн нэгжүүдийг үүсгэн хүлээн авч, бүртгэл хөтөлж архивласан байна. | |
| 3.1.9.2 | Аймгийн ГХБХБГ-ын архивт нэгж талбарын хувийн хэргийг сумдаас татан төвлөрүүлэх | Үйл ажиллагаа | Татан төвлөрүүлсэн нэгж талбарын хувийн хэргийн тоо | ГЗБГЗЗЕГ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, зааварчилгааны дагуу нэгж талбарын хувийн хэргийн баримтыг цэгцэлсэн. | **Жилийн эцэст:** 1 сумын 900 хувийн хэргийн бүрдлийг шалган акт үйлдэн хүлээн авч, мэдээг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | ГЗБГЗЗЕГ-аас 2024 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан сургалтаар нэгж талбарын хувийн хэргийг бүрдүүлэх цаасан материалыг тоон хэлбэрт шилжүүлэх зааварчилгаа өгсний дагуу 8931 нэгж талбарын цаасан хувийн хэргийг тоон буюу цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | 100 |
| **3.1.11** | **Хот байгуулалтын үйл ажиллагааны хэрэгжилт** | **Үйл ажиллагаа** | **Хэрэгжүүлсэн арга хэмжээ** | **-** | **Хот байгуулалтын чиглэлээр хийгдэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.** | | |
| 3.1.11.1 | Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хууль тогтоомжийн дагуу боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан баримт бичгийн тоо | - | **Эхний хагас жилд:** “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д шинээр батлагдсан хот суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний мэдээллийг оруулсан байна. | Шинээр хот суурины ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байна. Ерөө сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг “Ланд Овнер ХХК” хийж гүйцэтгэж байгаа бөгөөд холбогдох мэдээллээр бүрэн ханган ажилласан.<br>Мандал сумын хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө “Эрхэт костракшн ХХК” хийж гүйцэтгэж байгаа бөгөөд холбогдох мэдээллийг хүргүүлэхээр бэлдэж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.11.2 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлийн хэрэгжилтийг ханган ажиллах | Үйл ажиллагаа | Зардлын хэмжээ | Улсын хэмжээнд 162 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:** Монгол Улсын Засгийн газрын 2023 ны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 50 дугаар тэмдэглэлтэй холбоотойгоор төлөвлөгөө боловсруулах даалгаврын төслийг холбогдох норм, дүрмийн дагуу боловсруулан баталгаажуулж шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Шинээр хот суурины ерөнхий төлөвлөгөө батлагдаагүй байна. Ерөө сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг “Ланд Овнер ХХК” хийж гүйцэтгэж байгаа бөгөөд холбогдох мэдээллээр бүрэн хангаж ажилласан.<br>Мандал сумын хот байгуулалтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг “Эрхэт костракшн ХХК” хийж гүйцэтгэж байгаа бөгөөд холбогдох мэдээллийг хүргүүлэхээр бэлдэж байна.<br>Мөн 4 сумын Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай хөрөнгийг аймгийн 2025 оны төсөвт тусгуулахаар жишиг үнийн саналыг боловсруулан аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн бөгөөд тус үнийн саналыг сумдын Засаг даргын Тамгын газарт 2024.03.27-ны өдрийн 03/100 тоот албан бичгээр мөн хүргүүлж ажилласан. | 100 |
| **3.1.12** | **Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний мэдээллийг “Урбан менежер систем”-д бүртгэх** | **Үйл ажиллагаа** | **-** | **21 аймгийн 330 сумын мэдээлэл бүртгэгдсэн.** | **Улсын хэмжээнд барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний мэдээллийг бүртгэсэн байна.** | | |
| 3.1.12.1 | Шинээр барих барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл | Үйл ажиллагаа | Системд бүртгэсэн мэдээллийн тоо | Бүх сумдын барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн дэд бүтцийн мэдээлэл бүртгэгдсэн. | **Жилийн эцэст:** Шинээр нэмэгдсэн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл | Шинээр нэмэгдсэн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн мэдээллийг урбан цахим системд бүртгэх ажил явагдаж байна. 2024 оны жилийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээ, инженерийн дэд бүтцийн мэдээллийг "Урбан менежер систем"-д бүртгэх | | | | арга хэмжээ, инженерийн дэд бүтцийг мэдээллийг бүртгэсэн байна. | эцсийн байдлаар 1600 барилга байгууламж, 527 байршлын 1,438,648 м.кв ногоон байгууламж, 182 байршлын 103,207 м.кв авто зогсоол, 479,974 метр авто зам, замын байгууламж, гудамж талбайн гэрэлтүүлэг, 28 усан оргилуур, 65 хөшөө, дурсгал баримлын мэдээллийг бүртгэн баяжуулалт хийж ажиллаж байна.<br>Мөн инженерийн дэд бүтцийн мэдээллийг хангагч байгууллагуудтай хамтран мэдээллийн санд баяжуулан ажиллаж байна. | |
| 3.1.12.2 | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/-д өгөгдөл мэдээллийг бүрэн оруулж холбогдох журам, зааврын дагуу өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах | Үйл ажиллагаа | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/-д шинээр бүртгэгдсэн өгөгдөл, мэдээлэл | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/ хэрэглээнд нэвтэрсэн. | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/-д шаардлагатай өгөгдөл, мэдээлэл бүртгэгдэж холбогдох журам зааврын дагуу барилга, байгууламжийн бүртгэл, мэдээлэл хөтлөгдөж системийн өдөр тутмын үйл ажиллагаа тогтмол хийгдсэн байна. | Хот байгуулалтын кадастрын цахим систем /Urban.gov.mn/-д шаардлагатай өгөгдөл, мэдээллийг бүртгэж, холбогдох журам зааврын дагуу барилга, байгууламжийн бүртгэл, мэдээллийг хөтөлж, системийн өдөр тутмын үйл ажиллагааг тогтмол хангаж ажиллаж байна.<br>2024 онд Хот байгуулалтын цахим систем шинэчлэгдэж, хэрэглээнд нэвтэрсэнтэй холбоотой тус системийн цахим сайтын лого дизайны уралдаанд Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн өөрийн зохиосон бүтээлээрээ оролцон шалгарч, шинэчлэгдсэн цахим сайтын шинэ өнгө төрхийг бий болгоход хувь нэмрээ оруулсан. | 100 |
| **3.1.14** | **Худалдан авах ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **1 Төлөвлөгөө, 2 тайлан, ажил үйлчилгээний тоо** | **Ерөнхий төлөвлөгөөнд туссан 12 ажил, үйлчилгээний худалдан авалтыг хийж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, гэрээт ажлыг хүлээн авсан.** | **Ерөнхий төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөнд туссан ажлууд бүрэн хэрэгжиж, тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.14.1 | Байгууллагын 2024 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах, тайлагнах | Үйл ажиллагаа | 1 Төлөвлөгөө, 2 тайлан | 2023 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөө батлуулсан. | Худалдан авах ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулсан байна. Тайланг хагас, бүтэн жилээр гаргаж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан урсгал санхүүжилтээр бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг нэгтгэн гаргаж, www.shilendans.gov.mn-д ил тод байдлыг хангаж нийтлэн ажилласан. Үүнд:<br>– Бичиг хэргийн материал худалдан авах зардал-18,000.0 мянган төгрөг,<br>– тээвэр шатахууны зардал-15,000.0 мянган төгрөг,<br>– бага үнэтэй түргэн элэгдэх зардал-10,000.0 мянган төгрөг,<br>– нормын хувцас, зөөлөн эдлэл-12,000.0 мянган төгрөг,<br>– багаж техник хэрэгсэл худалдан авах зардал-70,000.0 мянган төгрөг,<br>– тавилга, эд хогшил худалдан авах зардал-40,000.0 мянган төгрөг,<br>– бараа АҮТХ зардал-30,000.0 мянган төгрөг,<br>– бусдаар гүйцэтгүүлсэн АҮТХ зардал-32,000.0 мянган төгрөгийг тус тус төлөвлөгөөнд батлуулж нийтэлсэн.<br>Тайлант хугацаанд гүйцэтгэлээр хуулийн дагуу холбогдох журмыг баримтлан бараа материал, хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор худалдан авалт хийж, гэрээний дагуу тогтсон хугацаанд санхүүжилтийг олгож ажилласан. Үүнд: 87,577.1 мянган төгрөгийн бараа материал, сэлбэг хэрэгслийг, 6,918.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийн ангиллын үндсэн хөрөнгүүдийг, 20,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авахаар төлөвлөн тус тус зохион байгуулж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн 2023 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр үлдэх өртөггүй, анхны өртгөө бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон, ашиглалтын хугацаа дуусан хөрөнгүүдийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох материалуудыг бүрдүүлэн актлах, дахин үнэлэх саналыг ГЗБГЗЗЕГ-т 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/385 тоот албан бичгээр хүргүүлээд байна. Үүнтэй холбоотойгоор байгууллагын хөрөнгийн сайжруулалт хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн байгууллагын хэмжилтийн тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дуусч, элэгдэн ашиглах боломжгүй болсныг аймгийн Засаг даргад уламжлан, 2025 оны төсөвт суулгаж өгөхийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/397 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлж ажилласан байна. | |

## ДӨРӨВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.1** | **Төрийн албаны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Тухай бүр** | **-** | | | |
| 4.1.1.1 | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухай бүр | - | Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад | 1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолоор “Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”, мөн 2024 оны 128 дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулсан байна. | тогтоолоор “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээ”-г тус тус шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Газрын даргын 2024 оны “Цалингийн санг шинэчлэн тогтоох тухай” А/04 дүгээр тушаалаар албан хаагчдын цалингийн санг шинэчлэн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс тооцон олгож байна.<br>2. “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу төрийн албанд болон тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үндэслэн нийт 7 албан хаагчид зэрэг дэв олгуулах саналыг Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлж, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2024 оны А/124 дүгээр захирамжаар 7 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгуулж, Газрын даргын 2024 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай” Б/08 дугаар тушаалаар цалингийн нэмэгдлийг олгон ажиллаж байна. | |
| 4.1.1.2 | Сул болон түр эзгүй байгаа орон тоог Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн | Үйл ажиллагаа | Сул болон эзгүй орон тоо | - | - Сул болон түр эзгүй байгаа орон тоо гарсан тохиолдолд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан байна | 1. Төрийн албаны тухай хууль, “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тухай, болон “Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэн ажиллуулах зар” мэдээллийг байгууллагын цахим хуудсуудад тус бүр 5 удаа байршуулж, олон нийтэд мэдээлэн, “Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөхөх, тусгай шалгалт зарлуулах тухай захиалгыг” аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд 5 удаа хүргүүлж, 8 ажлын байранд тусгай шалгалтыг зарлуулан ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллуулах журам”-ын хүрээнд сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах | | | | - Тухайн албан тушаалд нэр дэвшигчийн урьдчилсан мэдүүлгийг хянуулах, дүгнэлтийг үндэслэн шийдвэрийн төсөл боловсруулан албажуулах ажлыг зохион байгуулсан байна. | 2. Тайлант хугацаанд албан тушаалын томилготой холбоотой дараах шийдвэрүүдийг гарган ажиллалаа. Үүнд.<br>✓ “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу тухайн албан тушаалд ажиллах тусгай шаардлагыг хангаан, Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн 1 иргэнийг Газрын даргын Б/09 дүгээр тушаалаар төрийн жинхэнэ албанд томилон ажиллуулж байна.<br>✓ Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журмын дагуу 6 албан тушаалын сул орон тоонд 6 албан хаагчтай тус тус харилцан тохиролцож, Газрын даргын 6 удаагийн тушаалаар албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж байна.<br>✓ “Төрийн албаны тухай хууль”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам” болон албан хаагчийн хүсэлтийг үндэслэн бусад байгууллагын удирдлагатай харилцан тохиролцож, 1 албан хаагчийг Газрын даргын Б/01 дүгээр тушаалаар бусад байгууллагад шилжүүлсэн.<br>✓ Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлөөс 2024 оны “Нэр дэвшүүлэх тухай” 39 дүгээр тогтоолоор Газрын удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд 1 албан хаагчийг томилохоор нэр дэвшүүлсэн бөгөөд, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, Авлигатай тэмцэх газрын 2024.06.26-ны өдрийн “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай” 05/11081 тоот албан бичгийг үндэслэн албан хаагчийг Газрын даргын 2024 оны Б/11 дүгээр тушаалаар албан тушаалд дэвшүүлэн томилсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1.3 | “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөсөн арга хэмжээний тоо | “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр” /2021-2025/-ыг баталсан. | “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, биелэлтийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах” 6 үндсэн зорилт 22 арга хэмжээ бүхий 2024 оны төлөвлөгөөг боловсруулан, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр баталж, хэрэгжүүлж ажилласан. Тус хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн тайланг гарган ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн тайланг хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. | 100 |
| 4.1.1.4 | Салбарын хэмжээнд “Жэндэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Салбарын хэмжээнд Жендэрийн талаарх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төлөвлөгөөг Газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж биелэлтийг хагас, бүтэн жилээр гарган ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | Салбарын хэмжээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах бодлого, чиглэлийг баримтлан 8 арга хэмжээ бүхий “Жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэл”-ээр хэрэгжүүлэх ажлын 2024 оны төлөвлөгөөг боловсруулан, баталж хэрэгжүүлж ажилласан. Тус төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн тайланг гарган ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн тайланг хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. | 100 |
| 4.1.1.5 | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчлэх | Үйл ажиллагаа | Албан хаагчийн тоо | - | “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд мэдээллийг оруулах, тухай бүр шинэчилсэн байна. | Тайлант хугацаанд “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоо” цахим системд дараах өөрчлөлт, шинэчлэлтүүдийг тухай бүр оруулж ажиллалаа. Үүнд:<br>1. Газрын даргын 2024 оны “Цалингийн сан батлах тухай” А/01, “Цалингийн санг шинэчлэн тогтоох тухай” А/04 дүгээр тушаалуудын дагуу 2 албан хаагчийн албан тушаалын зэрэглэл, 36 албан хаагчийн цалингийн хэмжээнд орсон өөрчлөлтийг;<br>2. Газрын даргын 2024 оны “Ажлаас чөлөөлж, шилжүүлэх тухай Б/01, “Төрийн албанаас түр чөлөөлөх тухай” Б/05, “Ажлаас чөлөөлөх тухай” Б/17 дугаар тушаалуудын дагуу 3 албан хаагчийн ажлаас чөлөөлөгдсөн мэдээллийг; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Газрын даргын 2024 оны “Төрийн жинхэнэ албан тушаалд томилох тухай” Б/09, “Ажилд томилох тухай” Б/18, Б/21 дүгээр тушаалуудын дагуу 3 албан хаагчийн ажилд томилогдсон мэдээллийг;<br>4. Газрын даргын 2024 оны “Ажлаас чөлөөлж, шилжүүлэн ажиллуулах тухай” Б/11, Б/16 дугаар тушаалуудын дагуу 2 албан хаагчийн шилжин ажилласан мэдээллийг;<br>5. Газрын даргын 2024 оны “Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай” Б/02, Б/12, Б/15 дугаар тушаалуудын дагуу 3 албан хаагчийн цалингийн нэмэгдлийн мэдээллийг;<br>6. Газрын даргын 2024 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай” Б/08 дугаар тушаалын дагуу 7 албан хаагчийн цалингийн нэмэгдлийн мэдээллийг;<br>7. Газрын даргын 2024 оны “Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажилтныг томилох тухай” Б/10 дугаар тушаалын дагуу 1 албан хаагчийн цалингийн нэмэгдлийн мэдээллийг мөн нийт албан хаагчдын үндсэн мэдээлэлд орсон өөрчлөлтүүдийг тухай бүр бүртгэж ажилласан. | |
| 4.1.1.6 | Хүний нөөцийн тоо бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ, судалгааг ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх | Үйл ажиллагаа | Мэдээ, судалгааны тоо | - | Хүний нөөцийн чиглэлээрх салбарын албан хаагчдын бүх төрлийн нэгдсэн судалгаа, мэдээллийг цуглуулж, нэгтгэн цаг хугацаанд нь ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Байгууллагын “Хүний нөөцийн тоо бүртгэл, бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээ, судалгаа”-г цахимаар 2024.01.15-ны өдөр, 2023 онд “Шүүр” ажиллагааны хүрээнд илрүүлсэн зөрчил, тэдгээрийг арилгах талаар хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024.03.19-ний өдөр 01/85 тоот албан бичгээр, “Төрийн захиргааны албан хаагчид олгох мөнгөн урамшууллын журам”-ын дагуу урамшуулалд хамрагдах албан хаагчдын судалгааг 2024.05.07-ны өдөр 01/158 тоот албан бичгээр тус тус ГЗБГЗЗЕГ-т, “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийгдсэнтэй холбогдуулан байгууллагын бүтэц, орон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоо, цалинтай холбоотой дэлгэрэнгүй судалгааг гарган 2024.10.22-ны өдөр Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлэв.<br>Мөн холбогдох бусад мэдээ, судалгааг дээд шатны байгууллагуудад тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. | |
| **4.1.2** | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **12 удаа** | **-** | **Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг заасан хугацаанд оруулсан байна.** | | |
| 4.1.2.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Үйл ажиллагаа | Мэдээллийн тоо | - | Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын бараа, ажил үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөө, тайлан, санхүү, хөрөнгийн зарцуулалт, батлагдсан орон тооны мэдээлэл, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг сар бүр оруулж баталгаажуулсан байна. | Шилэн дансны тухай хуулийг 2015 оны 01 дүгээр сараас эхлэн мөрдөж эхэлсэн бөгөөд Шилэн дансны ил тод байдлыг хангах ажлын хүрээнд сар бүр болон тухай бүр хуулийн хугацаанд мэдээ тайланг шивж оруулан ажиллаж байна. Тайлант оны жилийн эцсийн байдлаар төсөв гүйцэтгэлтэй холбоотой 71 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой 39 мэдээлэл, бусад холбогдолтой 73 мэдээлэл буюу нийт 183 мэдээллийг тайлагнахаас нийт 159 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан бөгөөд 24 мэдээллийн хуулийн хугацаа болоогүй тул хүлээгдэж байна. | 100 |
| **4.1.3** | **Авлигын тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг** | **Үйл ажиллагаа** | **1 төлөвлөгөө, 3 тайлан,** | **-** | **Төлөвлөө болон тайланг холбогдох байгууллагад** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах** | | | | **хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.** | | |
| 4.1.3.1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнах | Үйл ажиллагаа | Тайлангийн тоо | 2023 онд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн. | Байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Газрын даргаар батлуулсан байна Хэрэгжилтийг хангаж, тайланг ГЗБГЗЗЕГ-т хагас, бүтэн жилээр хүргүүлсэн байна. | Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны 3 зорилго, 18 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг баталгаажуулан хэрэгжүүлж ажилласан. Тус төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн тайланг гарган аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн тайланг дээд шатны байгууллагуудад хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. | 100 |
| 4.1.3.2 | Албан тушаалтнуудын 2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үйл ажиллагааг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Мэдүүлэг гаргагчийн тоо | 2022 оны тайланг хугацаанд нь хүргүүлсэн. | Албан тушаалтнуудын 2023 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө авах ажлыг зохион байгуулсан байна. | Эрх бүхий 8 албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын шинээр мэдүүлсэн мэдүүлгийг цаасан хэлбэрээр 2023 оны 01-р сарын 16-ны өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдрүүдэд, мөн нийтийн албан тушаалд томилогдсон 1 албан хаагчийн шинэчлэн мэдүүлсэн мэдүүлгийг хуулийн хугацаанд багтаан Авлигатай тэмцэх газрын www.meduuleg.iaac.mn програмд шивэн албан хаагч бүрээр гарын үсэг зуруулж баталгаажуулж ажилласан. | 100 |
| 4.1.3.3 | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг хүлээн авч бүртгэх | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг албан хаагчдаас хүлээн авч бүртгэх, шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | Тайлант хугацаанд 105 төсөл арга хэмжээнд барилга байгууламжийг улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан бөгөөд Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралтад тусгагдсан албан хаагчдаар “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг бөглүүлж, бүртгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.3.4 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Мэдүүлгийн тоо | - | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна. | Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн 2024.06.05-ны өдрийн "Нэр дэвшүүлэх тухай" 39 дүгээр тогтоолын дагуу Газрын удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд 1 албан хаагчийг томилохоор нэр дэвшүүлж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг 2024.06.11-ний өдрийн 01/217 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хянуулж ажилласан. | 100 |
| **4.1.4** | **Тогтоол шийдвэрийн, биелэлтэд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Тогтоол шийдвэрийн бүртгэл хөтөлсөн байдал** | **78 тогтоол шийдвэрийн биелэлтийг журамд заасан хугацаанд тайлагнасан.** | **Бүртгэлд авсан тогтоол шийдвэрийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журамд заасан хугацаанд холбогдох газарт тайлагнасан байна.** | | |
| 4.1.4.1 | Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗЕГ болон бусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг бүртгэх, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах | Үйл ажиллагаа | Тогтоол, шийдвэрийн тоо | - | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хүлээн авч бүртгэлжүүлэн, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр холбогдох газарт тайлагнасан байна. | Улсын Их Хурал, Засгийн газар, яам, бусад байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн бүртгэл хөтлөх, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, биелэлтийг нэгтгэж, зохих газарт тайлагнах зорилтын хүрээнд:<br>1. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн 3 арга хэмжээ<br>2. Засгийн газрын 8 тогтоол<br>3. Засгийн газрын 6 хуралдааны тэмдэглэлд тусгагдсан 7 арга хэмжээ<br>4. Засгийн газрын 2 албан даалгаврын 2 арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг сар тутам аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.<br>Мөн аймгийн Засаг даргын захирамж, Төрийн албаны зөвлөл, ГЗБГЗЗЕГ-ын даргын тушаал шийдвэрүүдийг бүртгэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. | 100 |
| **4.1.5** | **Байгууллагын хэмжээнд эрх зүйн баримт бичиг боловсруулалт, хэрэгжилтэд хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **380 тушаал, 280 гэрээ, 1 журам, 1 эмхэтгэл** | **-** | **Тушаал болон гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаж, дугаар олгож бүртгэсэн байна. Хөдөлмөрийн** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **дотоод журамд нэмэлт өөрчлөлт орж батлагдсан байна. Эмхэтгэл бэлэн болсон байна.** | | |
| 4.1.5.1 | Газрын даргын тушаалын үндэслэлийг хянаж, бүртгэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тушаалын төслийн тоо | 2023 онд 70 тушаал гарч албажсан байна. | Газрын даргын тушаалын төслийг боловсруулж, бүртгэл хөтөлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн тайланг гаргасан байна. | Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулиудыг мөрдөж ажиллах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам болон Төсвийн тухай хуулиудтай нийцүүлэн хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой 21 тушаалын төсөл, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 18 тушаалын төслийг боловсруулах, хянах, бүртгэх ажлыг хийж гүйцэтгэн холбогдох албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| 4.1.5.2 | Байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, албажуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Шинэчлэн боловсруулсан дүрэм, журмын тоо | - | Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. | Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн албан хаагчдын ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан байдлыг хангах зорилгоор байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д Газрын даргын 2023 оны А/16 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор байгууллагын “Ес зүйн дэд хороо, түүний ажиллах журам”-г Газрын даргын А/18 дугаар тушаалаар байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| **4.1.6** | **Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, дүгнэх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2023 оны 98 дугаар тушаалаар батлагдсан загвар, аргачлал** | **Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор журам шинэчлэн батлагдсан.** | **Журамд заасан хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнасан байна.** | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.6.1 | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Үнэлгээний мөрөөр авсан арга хэмжээний тоо | 2023 онд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг жилээр, гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр гарган үнэлгээ, дүгнэлт өгч ажилласан. | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлах ажлыг зохион байгуулж, биелэлтийг үнэлж, үнэлгээний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | 2024 оны ажлын жилд "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө"-г төрийн захиргааны 4 албан хаагч харьяалах нэгжийн даргаар, 16 албан хаагч харьяалах сумын Засаг даргын Тамгын газрын даргаар болон төсвийн шууд захирагчаар, 10 албан хаагч төсвийн шууд захирагчаар тус тус батлуулан эхний хагас жилийн болон жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолд заасан хугацаанд багтаан дээд шатны албан тушаалтанд ирүүлсэн бөгөөд эхний хагас жилийн тайланг үнэлж, дүгнэн Газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн "Албан хаагчдад урамшуулал олгох тухай" А/11 дүгээр тушаалаар 33 албан хаагчид урамшуулал олгосон. Мөн жилийн эцсийн тайланг үнэлж, дүгнэх ажлыг хийж гүйцэтгэхээр бэлтгэн ажиллаж байна. | 100 |
| **4.1.7** | **Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдалтын хувь** | **-** | **Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тусгай зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.** | | |
| 4.1.7.1 | Сумын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Үйл ажиллагаа | Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан сумдын тоо | - | Сумын газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хэлэлцэж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. | Газрын даргын 2024 оны А/03 дугаар тушаалын дагуу Алтанбулаг, Сайхан сумын газрын даамлын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан бөгөөд гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцэн, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах, цаашид анхаарах асуудлаар зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.8** | **Хурал, зөвлөгөөн зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | | **2021 онд 5 хурал, 3 зөвлөгөөн зохион байгуулагдсан.** | **Хурал, зөвлөгөөн, форумыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлтийг тайлагнасан байна.** | | |
| 4.1.8.1 | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зарлагдсан "Бүтээлч ажил"-ыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | Бүтээлч ажлын тоо, Хэрэгжилтийн байдал | - | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөө болон зарлагдсан бүтээлч ажлуудыг орон нутагтаа зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Монгол улсад Газрын харилцааны мэргэжлийн байгууллага үүсэж хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зарлагдсан "Бүтээлч ажил"-ыг хэрэгжүүлэх 6 зорилт 28 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд биелэлтийн тайланг гарган ГЗБГЗЗЕГ-т 2024.09.13-ны өдөр хүргүүлсэн. | 100 |
| **4.1.9** | **Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь** | **Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр батлагдсан.** | **Хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.** | | |
| 4.1.9.1 | Батлагдсан "Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Сургалтын тоо | - | "Салбарын хэмжээнд байгууллагаас хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө"-г боловсруулан Газрын даргаар батлуулж, хэрэгжүүлж ажилласан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр ГЗБГЗЗЕГ-т тайлагнасан байна. | Салбарын хэмжээнд зохион байгуулах зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтын 2024 оны 22 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр баталж, хэрэгжүүлж ажилласан. Тус төлөвлөгөөний 2024 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийн тайланг гарган ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн биелэлтийн тайланг гарган ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. | 100 |
| 4.1.9.2 | Салбарын хууль тогтоомжийн хүрээнд ГХБХБГ-ын албан хаагчдыг | Үйл ажиллагаа | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | - | Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар болон салбарын хууль | Тайлант хугацаанд сумын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон сумдын газрын даамлуудыг мэргэжил арга зүйгээр хангаж, сургалт зохион байгуулах | | | | тогтоомжийн хүрээнд байгууллагын албан хаагчид, сумын газрын даамлуудад сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүгээр хангаж ажилласан байна. | зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>1. НҮБ-ын Хүнс, хөдөө, аж ахуйн байгууллага СТРИЙМ төслийн санхүүжилтээр Ерөө, Жавхлант, Мандал сумдын “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө”-ний бодлогын бичиг баримтыг боловсруулан аймаг, суманд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан бөгөөд сумдын газрын даамлуудыг 1 өдрийн танхимын сургалтад хамруулав.<br>2. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуультай уялдуулан Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэх талаарх цахим сургалтыг зохион байгуулж, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, Газрын даамлуудыг хамруулав.<br>3. Засгийн газрын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” 92 дугаар тогтоол, “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-д орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх цахим сургалтад сумдын даамлуудыг хамруулав.<br>4. ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/253 “Ажлын хэсэг” байгуулан хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу захирамжийн бүртгэлтэй холбоотой Кадастрын хэлтсээс зохион байгуулсан сургалтад холбогдох мэргэжилтнүүд болон Газрын даамлуудыг хамруулав.<br>5. Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд орсон өөрчлөлттэй холбоотой цахим сургалтуудад албан хаагчдыг бүрэн хамруулсан. Цахим сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгааг ГЗБГЗЗЕГ-ын Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **4.1.10** | **Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод, шуурхай байх нөхцөл боломжийг бүрдүүлэх** | **Үйл ажиллагаа** | - | - | **Байгууллагын үйл ажиллагааны мэдээ олон нийтэд шуурхай хүрдэг болсон байна.** | | |
| 4.1.10.1 | Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Салбарын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр сурталчилсан. | Салбарын үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээг орон нутгийн хэмжээнд сурталчлан таниулж, нийтэд хүргэх арга хэмжээг зохион байгуулсан байна. | - Байгууллагын болон egazar.gov.mn-ийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, танилцуулах зорилгоор аймгийн хэмжээнд Сайхан сум, Мандал сум, Цагааннуур сумдад бүсчилсэн хэлбэрээр “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулж, 384 иргэн, аж ахуйн нэгж, мөн сумдын ИТХ-д шинээр томилогдсон төлөөлөгч нарт мэдээллийг хүргэсэн байна.<br>- Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуультай уялдуулан Газрын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, малчин өрхийн амьжиргааг дэмжих, тус хөдөлгөөнийг орон нутагт өрнүүлэх, сурталчлан таниулах зорилгоор Ерөө, Сайхан, Баянгол, Мандал, Жавхлант 2024 оны 5, 6 дугаар сард ажиллаж, сумын малчид болон мал бүхий иргэдэд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд олгох газрыг төсөл сонгон шалгаруулалтын зарчмаар хэрхэн олгох талаарх мэдээлэл болон Газрын тухай хуультай холбоотой бусад мэдээллийг өгч ажиллав.<br>- Газрын төлбөр, татварыг цахимаар хэрхэн төлөх болон газрын үнэлгээний талаарх мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэлийн багтай хамтран бэлтгэж, аймгийн Засаг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даргын Тамгын газрын албан ёсны цахим хуудсуудад байршуулж ажилласан. Мөн энэ талаарх мэдээллийг аймгийн Онцгой байдлын газрын 28 албан хаагч, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн 32 албан хаагчдад өгч ажилласан.<br>- Салбарын үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлах ажлыг зохион байгуулах, зорилгоор *www.selenge.gazar.gov.mn* вэб хуудас, *Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар* фэйсбүүк хуудсуудад байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт **139** мэдээллийг байршуулж, олон нийтэд сурталчилж ажилласан. Мөн байгууллагын олон нийтэд зориулсан ханын самбарт салбарын үйл ажиллагаатай холбоотой гарын авлага, хууль тогтоомж, мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж ажиллаж байна. | |
| **4.1.11** | **Албан хэрэг хөтлөлтийн ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа ны зардал** | **Баримт бичиг** | **2022 онд 3600 албан бичиг, 500 өргөдөл, гомдол хүлээн авсан.** | **Газарт ирсэн, явсан, өргөдөл гомдлыг "Байгууллагын удирдлагын цогц цахим систем"-д бүртгэлжүүлж, тайлан мэдээг гаргасан байна.** | | |
| 4.1.11.1 | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэж, тайлагнах | Үйл ажиллагаа | Ирүүлсэн албан бичгийн тоо, Явуулсан албан бичгийн тоо, Өргөдлийн тоо, Тайлангийн тоо | 2023 онд 1168 албан бичиг, 222 өргөдөл, гомдол хүлээн авч, 466 албан бичигт дугаар олгон холбогдох иргэн, хуулийн этгээдэд хүргүүлсэн. | - Байгууллагад ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байна.<br>- Байгууллагаас явуулж буй албан бичгийг бүртгэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Тайлант оны жилийн эцсийн байдлаар байгууллагад ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг бүртгэл хяналтын карт хөтлөн бүртгэж, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн ажилласан байна.<br>- Бусад байгууллагуудаас 1100 бичгийг хүлээн авч, хаяг бүртгэлийг шалгаж, бүртгэл хяналтын карт хөтлөн ирсэн өдөрт нь багтаан удирдлагад танилцуулж, нэр заасан, хариуцан шийдвэрлэх албан тушаалтанд хүлээлгэн өгч, шийдвэрлэлтийн байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Мөн хугацаа заан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Хариутай албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн мэдээ тайланг тухай бүр гаргаж, тайлагнасан байна.<br>- Өргөдөл, гомдлын мэдээг холбогдох байгууллагад улирал бүр тайлагнасан байна. | ирүүлсэн 167 албан бичгийн хариуг тухай бүр холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.<br>- Аймгийн Засаг даргын Тамгын газар, Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв /1111/-ээс хугацаа заан ирүүлсэн 36 иргэний өргөдөл гомдол хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь хариу хүргүүлсэн.<br>- Тайлант хугацаанд 208 иргэнээс цаасан байдлаар ирүүлсэн өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэлтийн мэдээ тайланг Засаг даргын Тамгын газарт сар, улирал бүр гаргаж, тайлагнасан байна. | |
| **4.1.12** | **Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах** | **Үйл ажиллагаа** | **Хадгаламжийн нэгж** | **Байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 онд 358 хадгаламжийн нэгж үүсгэсэн.** | **Байгууллагын архивт баримт хүлээн авах, бүртгэх, нягтлан шалгалт хийх, тоо бүртгэл хөтлөх, тооллого явуулах, хадгалах, хамгаалах, ашиглуулах, данс бүртгэл хөтлөх, устгах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулсан байна.** | | |
| 4.1.12.1 | Байгууллагын архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах | Үйл ажиллагаа | Хадгаламжийн нэгжийн тоо | 2023 онд Байгууллагын хөтөлж дууссан баримтыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн архивласан. | 2024 оны байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, нөхөн бүрдүүлэх хуваарь гарган батлуулсан байна.<br>2023 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт” болон нөхөн бүрдүүлэх хуваарийн дагуу хөтөлж дууссан баримтыг хадгаламжийн нэгж | Байгууллагын 2024 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт /ХХНЖ/”-ыг боловсруулж, ХХНЖ-аар нөхөн бүрдүүлэх хуваарь гарган БНШК-ын хурлаар батлуулсан.<br>2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан хаагчдын хөтөлж дууссан баримт бичгийн бүрдлийг шалгаж байнга хадгалах 10 хадгаламжийн нэгж, түр хадгалах 40 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 1 хадгаламжийн нэгж буюу нийт 51 хадгаламжийн нэгжүүдийг үүсгэн хүлээн авч, бүртгэл хөтөлж архивласан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үүсгэн архивласан байна. | | |
| 4.1.12.2 | Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын дотоод зохион байгуулалтын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг зохион байгуулж, байгууллагын архивын чиг үүргийг хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | - | **Жилийн эцэст:** Улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлж, дүгнүүлсэн байна. | Архивын Улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 100 |
| **4.2.1** | **Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх** | **-** | **Санхүүгийн хяналт шалгалтын дүн** | **Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг ил тод тайлагнаж ажилладаг.** | **Санхүүгийн зөрчилгүй ажилласан байна.** | | |
| 4.2.1.1 | Төсвийн зардлыг бууруулж, хэмнэлт гаргаж ажиллах, бараа материалын болон үйлчилгээний орлогод хяналт тавьж орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-н тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан байна. Орлогын төлөвлөгөөг биелүүлж санхүү төсвийн зөрчилгүй ажилласан байна. | 2024 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийн дагуу улсын төсвийн санхүүжилтээр 1,528,579.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 125,000.0 мянган төгрөг буюу нийт 1,653,579.9 мянган төгрөгийн төлөвлөгөөний дагуу төсвийг зориулалтын дагуу зарцуулав. Тайлант хугацаанд нийт төсвийн 80.43%-ийг цалин хөлс нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардалд, 0.3%-ийг хангамж бараа материалын зардалд, 0.19%-ийг томилолтын зардалд, 0.01%-ийг норматив зардалд, 2.08%-ийг эд хогшил худалдан авах, урсгал засварын зардалд, 6.22%-ийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ төлбөр хураамжийн зардалд, 1.79%-ийг бараа үйлчилгээний бусад зардалд, 8.53%-ийг ажил олгогчоос олгох тэтгэмж урамшлын зардалд, 0.45%-ийн байр ашиглалттай холбоотой зардалд тус тус батлагдан зориулалтын дагуу зарцуулж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байгууллагын нэмэлт санхүүжилтээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 89,775.3 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчдаас 3,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 139,422.8 мянган төгрөгөөр тус тус санхүүжсэн байна. Үүнээс:<br>• Засгийн газрын 2018 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан орон нутгийн нэмэгдлийг аймгийн ИТХ-ын 142 дугаар тогтоолоор 2024 оны 01 дүгээр сараас эхлэн төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийн 30%-ийг олгохоор баталсны дагуу сар бүр санхүүжилтийг сар бүрийн гүйцэтгэлээр тооцоолон, 30 албан хаагчдад 139,422.8 мянган төгрөгийн нэмэгдлийг олгосон байна.<br>• Мөн Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 83 тоот тушаалаар батлагдсан хуваарийн дагуу төсвийг зүй зохистой эдийн засгийн ангиллын дагуу зарцуулан ажиллаж байна.<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийг чанд сахиж, Сангийн сайдын 282 дугаар тушаалаар батлагдсан журмын хавсралтын дагуу төсвийн зарлагын хэмнэлт, хэтрэлтийн тооцоо судалгааг боловсруулан хэмнэлттэй байгаа зардлаас дутагдалтай байгаа зардалд зардал хооронд гүйлгэн зарцуулах саналыг ГЗБГЗЗЕГ-т саналыг хүргүүлж, төсөвт 1 удаагийн өөрчлөлтийг оруулж, төсвийг зүй зохистой, хяналттай, удирдан, зохион байгуулж ажилласан. | |
| 4.2.1.2 | Байгууллагын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж, аудитын дүгнэлт гаргуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | Байгууллагын 2023 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, тогтоол, УСНББ-ийн олон улсын стандарт, НББ-ийн бодлогын баримт бичигт тулгуурлан аккруэль суурьт үндэслэн үнэн зөв, шударга илэрхийлж, 2024 оны 01 дүгээр сарын 15-ны хуулийн хугацаанд нь тайлагнан аймгийн Аудитын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газраар шалгуулж, “өөрчлөлтгүй дүгнэлт” авч дээд шатны байгууллага ГЗБГЗЗЕГ болон аймгийн Төрийн санд нэгтгүүлж, ил тод байдлыг хангах үүднээс шилэн данс болон сангийн яамны э-тайлан, программуудад хугацаанд нь шивж, нэгтгүүлж ажиллалаа. | |
| 4.2.1.3 | Өр авлагыг цаг тухайд нь барагдуулж, өмнөх оныхоос бууруулж ажиллах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үүссэн өр, авлагыг цаг тухайд нь барагдуулж тайлант жилд өр, авлагыг бууруулан ажилласан байна. | Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, НББ-н бодлогын баримт бичиг болон бусад хууль, УСНББ-ийн олон улсын стандартын дагуу шинээр өр авлага үүсгэлгүй, бараа материалын орлого, зарлагад тухай бүр хяналт тавьж ажиллаж байна.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар боломжтой зардлыг аль болох хэмнэж, өр үүсгэлгүйгээр нэн шаардлагатай байгаа зардлыг боломжит зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулах хүсэлтийг Сангийн сайдын А/282 тоот тушаалын дагуу ГЗБГЗЗЕГ-т 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/188 тоот албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлэн ажиллаж байна. | 100 |
| 4.2.1.4 | Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Үндсэн хөрөнгийн болон бараа материалын ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж ажилласан байна. | Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавих ажлын хүрээнд тооллогын ажлыг зохион байгуулахаар Газрын даргын 2024 оны 06 сарын 03-ны Б/09 дүгээр тушаалаар тооллогын комиссыг байгуулж, хагас жилийн бараа материал, үндсэн хөрөнгийг нэг бүрчлэн тоолж, албан хаагчдын эд хөрөнгийн картыг шинэчлэх ажлыг зохион байгуулж ажилласан.<br>Тооллогын явцын дүгнэлтээр илүүдсэн, дутсан хөрөнгө байхгүй бөгөөд эдэлгээний явцад цаашид ашиглагдах боломжгүй, үлдэх өртөг дууссан бараа материал болон үндсэн хөрөнгийг, өмч хамгааллын байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэж картад тэмдэглэл хөтлөн бүртгэлжүүлсэн бөгөөд байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөс гаргасан шийдвэрийг үндэслэн 96 ширхэг актлах саналтай, 29 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ширхэг дахин үнэлэх саналтай хөрөнгүүдийн судалгаа тооцоог нэгтгэн гаргаж, ГЗБГЗЗЕГ-т 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01/385 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан.<br>Төрийн өмчийг эзэмшүүлэх, ашиглалтад хяналт тавьж ажиллах, 2023 оны гэрээг дүгнэх, 2024 оны гэрээ байгуулах ажлын хүрээнд https://umch.sgov.mn сайтад хөрөнгийн хөдөлгөөний мэдээллийг бүрэн шивж оруулан, ил тод байдлыг хангаж ажилласан бөгөөд 96%-тай дүгнүүлсэн байна.<br>Тайлант хугацааны жилийн эцсийн байдлаарх хөрөнгийн тооллогын ажлыг 12 дугаар сарын 15-20-ны өдрүүдийн хооронд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| 4.2.1.5 | Санхүү болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, татвар, НДШ-ийн тайлан, Шилэн дансанд оруулах мэдээллийг хууль журамд заасан хугацаанд оруулж мэдээ тайланг холбогдох газруудад хүргүүлсэн байна. | Үйл ажиллагаа | Санхүүгийн зөрчилгүй ажилласан байх | Төсвийн тухай болон НББ-ийн тухай, Шилэн дансны тухай хуулийн дагуу Санхүү, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын тайлан мэдээг хуулийн хугацаанд тайлагнаж ажилласан. | Хуульд заасан хугацаанд мэдээ тайланг тайлагнаж ажилласан байна. Мэдээ тайлангийн хугацааг хоцроохгүй байх. | Тайлант хугацаанд төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүрийн хуулийн хугацаанд нийт 11 удаа гаргаж, НДШ-ийн тайланг сар бүр 11 удаа, ХХОАТ-ын тайлан мэдээг улирлаар 3 удаа хугацаанд нь тайлагнасан бөгөөд 12 дугаар сар болон 4 дүгээр улирлын тайланг гарган хуулийн хугацаанд тайлагнахаар тооцоолон ажиллаж байна.<br>2024 оны эцсийн жилийн байдлаар www.shilendans.gov.mn сайтад төсөв гүйцэтгэлтэй холбоотой 71 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой 39 мэдээлэл, бусад холбогдолтой 73 мэдээлэл буюу нийт 183 мэдээллийг тайлагнахаас 159 мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулсан бөгөөд 24 мэдээлэл нь хуулийн хугацаа болоогүй тул хүлээгдэж байна.<br>Мөн төсвийн захирагчийн баталгаажуулах 4-р улирлын тайланг илгээхээр бэлтгэлийг хангаан гүйцэтгэлүүдийг гаргаж, бусад шаардлагатай мэдээ, тайлан, тогтоол, тушаалын ил тод байдлыг мэдээллийн самбарт байршуулан ажилласан. | 100 |

--oOo--